

Огноо: 2015.03.31

№ 7-15/15

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ХААН ДААТГАЛ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

Бид “ХААН ДААТГАЛ” ХХК-ийн (шаашид “Компани” гэх) 4-7 дугаар хуудсанд тусгагдсан 2014 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд ба бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж үнэн зөв танилцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогоо сонгож, түүнийг тайлант жилийн туршид тогтвортой мөрдөх, бүртгэлээ хуулийн дагуу зохион байгуулах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага болно. Мөн түүнчлэн хөрөнгийн халгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, хөрөнгийг янз бүрийн зальт ажиллагаанд өртүүлэхгүй байхаар дотоод хяналтын системийг бий болгох, хэрэгжүүлэх нь удирдлагын хариуцлага юм.

Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргасан үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Холбооны Аудит Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр Стандарт нь санхүүгийн тайланг материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор ашиглах төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажил нь санхүүгийн тайлан дах зөрчил болон тодрууллагын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багасгахтай холбоотой. Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг тайлагналттай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдвэр сонгож авна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын систем үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш бөгөөд гухайн нөхцөл зохистой аудитын горимуудыг хэрэглэхийн тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтын аудитор яви үздэг.

...аудитын ажил нь санхүүгийн тайлан бүхэл нь үнэлэх гэж байна. ...дүгээс хийсэн тооцоолол, хэрэглэсэн бүртгэлийн зарцуудыг шалгах ажилыг ...агуулагд. Бидний хийсэн аудитын ажил нь дээр санхүүгийн тайлан дүгнэлт гаргах ...тай үндэслэл болж чадна гэж үзлээ.

Тайлбарын үндэслэл

- Жилийн эцсийн санхүүгийн тайланд 395,139.4 мянган тогрөгийн авлага тайлагнаснаас 86.02% буюу 339,884.7 мянган тогрөгийн авлага дотооноо байгууллагаас авах авлага дансанд харилцагчид гэсэн ерөнхий нэр дээр бүртгэсэн бөгөөд үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, мөн аудитын торимжор тулган баталгаажуулах боломжгүй байна.

Энэ нь эрх ба үүрэг, оршин байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдүүдийг хангахгүй байна.


Аудитын хязгаарлалттан санал дүгнэлт

Дээрх тайлбарын үндэслэлийг эс тооцвол "ХААН ДААТГАЛ" ХХК-ийн 2014 оны 1 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийг хувьд балансын өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдал, орлогын дүн эр нэг өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн Тайлангаар Олон Улсын Стандарт болон Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүний үндсэн мөрдөж байгаа холбогдох заавар, журмын дагуу зөв зүйтэй илэрхийлсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 8-36 хүртэлх хуудлах тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бусад

Энэхүү дүгнэлт нь өөр аливаа нэг этгээдэд биш, Монгол улсын "Компанийн хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох компанийн хувь нийтлүү зориулан, тэдний хүсэлтийн дагуу энэхүү тайланг гаргасан болно. Бид энэхүү тайлангуудын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.


 "Пантер Мидланд Аудит" ХХК
 Гүйцэтгэх захирал Д.Билэгсайхан